

Сүүлийн 25—30 жилийн дотор хөгжиж байгаа орнууд дундаас Гонконг, Сингапур, Тайван болон Өмнөд Солонгос эдийн засгийн хөгжлийн хурдцын үндсэн үзүүлэлтээр тод ялгарсан билээ. Уг үзүүлэлт бодит орлого, нэг хүнд ноогдох бодит хэрэглээний өсөлтийг хамрахаас гадна хүн амын дундаж наслалт, боловсролын түвшин зэрэг нийгэмийн үзүүлэлтийг хамарч байна. Тиймээс ч энэ дөрвийг нийцүүлэн «Азийн дөрвөн бар» хэмээн нэрлэх нь түгээмэл болсон юм.

Дөрвөн барын хөгжлийн зам тус тусдаа өөрийн онцлогтой нь мэдээж. Ялангуяа хотулс болох Гонконг, Сингапурын жишээ бусад Хөгжиж буй орнуудаас нэлээд ялгаатай юм. Харин Өмнөд Солонгос болон Тайван нь улс төр, хүн ам, газар зүйн нөхцөл байдлаараа бусад хөгжиж буй орнуудтай нийтлэг тал олонтой, тэдний ерөнхий хэв шинжийг агуулсан гэж хэлж болно. Тиймээс энэ хоёр барын хөгжлийн гарааны нөхцөл байдал ямар байв, тэдний эдийн засгийн бодлогод ижил болон ялгаатай талууд юу байв, бусад хөгжиж буй орнуудад сургамж болох нийтлэг зүйл юу байна вэ гэдэг нь туйлаас чухал.

Нэг. Тайван, Өмнөд Солонгосын хөгжлийн гарааны онцлог байдал

1950-аад оны эхэн үеийн Тайван, Өмнөд Солонгосыг аваад үзэх юм бол тэр үеийн шинэ залуу хөгжиж эхэлж байсан олон оронтой, ижил буюу төстэй нөхцөл байдалд гараагаа эхэлсэн гэж хэлж болно.

Дөнгөж колонийн өвөөс ангижран бие даасан хөгжлийн замд гарсан хөгжиж буй орнуудын дийлэнх нь газар тариалангийн үйлдвэрлэл голлосон, аж үйлдвэр эхлэлийн төдий байлаа. Тиймээс ч тэд импорт орлуулах аж үйлдвэрийг хөгжүүлж, дотоодын цөөн тооны аж үйлдвэрээ улсын ивээлд тэтгэн хөгжүүлэх хөгжлийн стратегийг сонгож авах нь нийтлэг байв. Тайван, Өмнөд Солонгос ч эхэн үедээ энэхүү нийтийн жишгийг дагалдах байдалтай байсныг хэлэх хэрэгтэй.

Гэвч Тайван 1950-аад оны дундаас, Өмнөд Солонгос 1960-аад оны эхнээс нийтийн жишгийг зоригтойгоор зөрчин хөгжлийн шинэ стратегийг баримтлах болсон нь тэдний цаашдын хөгжлийг бусдаас эрс ялгаатай болох үндсийг тавьж өгчээ. Энэхүү хөгжлийн шинэ стратеги нь импортыг орлуулах бус харин экспортыг бүх талаар урамшуулах бодлого байсан юм.

Чухамдаа яагаад ийм экспортыг урамшуулах сонголт хийх болсон юм бэ? Тайваны хувьд 1950-аад оны эхээр импортыг хязгаарлахын тулд импортын төрөл тус бүрд өөр өөр валютын солилцооны ханш тогтоожээ. Ингэснээр чухал түүхий эдийг импортлоход хямд буюу дөхөмтэй, хэрэглээний зүйлийг импортлоход үнэтэй төвөгтэй байлгах зорилго тавьж байв. Түүнчлэн санхүү банкны байгууллага банкны зээллэгийн хүүг зохиомлоор бага түвшинд барьж байлаа. Гэвч ийм бодлого үр ашиггүй болох нь удалгүй ойлгогдсон байна. Иймээс 1950-иад оны

* ШУА-ийн Дорнодахин олон улс судлалын хүрээлэнгийн захирал, түүхийн ухааны дэд доктор

дундуур зээллэгийн хүүг хэд дахин нэмсэнээр мөнгөний хязгаарлагдмал нөөцийг зохистой ашиглах бололцоо бүрдэв. Мөн 1958 онд валютын солилцооны ханшийг нэг мөр болгосноор гадаад валютын хомсхон нөөцөө ямар ч аргаар хадгалах бус харин энэ нөөцөө арвижуулах эхлэлийг тавьжээ. Импортыг хязгаарлахын тулд валютын солилцооны ханшийг албаар доогуур барьж байсныг халж дээгүүр тогтоосноор экспортыг нэмэгдүүлэх нөхцөл бий болов.

Үүний зэрэгцээ экспортыг урамшуулахын тулд экспортын бүтээгдэхүүнийг боловсруулах тусгай бүсийг байгуулах, экспортын үйл ажиллагааг дэмжих бага хүүтэй зээллэгийг олгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Энэ бүх арга хэмжээг авсаны дүнд нийт экспортын хэмжээ 1960-аас 1970 оны хооронд 10 дахин нэмэгдсэн бол импорт мөн хугацаанд 6 дахин нэмэгдсэн байна. Экспортыг урамшуулах тууштай бодлого мөн аж үйлдвэрийн бүтцэд гүнзгий өөрчлөлт гаргав. Дотоодын нийт бүтээгдэхүүнд газар тариалангийн салбарын эзлэх хувь 1960 онд 28,7% байсан бол 1970-онд 15,5 % болон буурч, харин боловсруулах аж үйлдвэрийн эзлэх хувь мөн хугацаанд 29,5% -аас 41,3% болж нэмэгдэв. Нэг хүнд ноогдох ҮНБ-ий хэмжээ ч энэхүү 10 жилийн дотор 153-аас 387 ам. доллар болж 2,5 дахин шахуу болж нэмэгджээ¹.

Өмнөд Солонгосын хувьд ч 1960-аад оны эхээр өмнө нь баримталж байсан импорт орлуулах бодлогоо (1948—1960 онд) халж экспортыг бүх талаар урамшуулах замыг сонгож авсан байна. Ийм замыг сонгож авахад Өмнөд Солонгосын хэд хэдэн бодит хүчин зүйл, ялангуяа ашигт малтмалын нөөцөөр хомс, нөлөөлсөн нь гарцаагүй. Тайваны нэгэн адил Өмнөд Солонгос нь экспортын чиглэлтэй боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлийг баримталсан юм. Тэгэхдээ 20 сая хүн амтай Тайваныг бодвол 2 дахин илүү хүн амтай, бас дотоод зах зээлийн багтаамж харьцангуй ихтэй тул Өмнөд Солонгос автомашин, өнгөт телевизор, ган ширэм, нефть хими зэрэг овор ихтэй хүнд аж үйлдвэрийг түлхүү хөгжүүлэх бололцоотой байлаа. Экспортыг урамшуулахын тулд засгийн газар банкны зээллэг, татварын хөнгөлөлт зэрэг хэд хэдэн хөшүүргийг ашиглажээ. Өмнөд Солонгост банкны зээллэгийн хүүг тун багаар тогтоосноор зээллэг авах шаардлага хэрэгцээг байнга өндөрт байлгаж байв. Засгийн газар банкны зээллэгээр дамжуулан экспортын чиглэлтэй аж үйлдвэрийг урамшуулах бодлого явуулж иржээ. Албан татварын бодлого ч пүүс компаниудын экспортоос олсон орлогыг шууд бус татвараас 100 %, ашгийн татвараас 50 % чөлөөлөх хүртэл хөнгөлөлт үзүүлэхэд үйлчилдэг байв. Түүнчлэн 1960-аад онд Сеул. Масан болон Куми зэрэг газарт экспортын чиглэлтэй аж үйлдвэрийн бүсийг бий болгож газрыг хөнгөлөлттэй үнээр зарж, эрчим хүч, ус зэрэг дэд бүтцийн зардлыг ч засгийн газрын үнээр үйлчилж байв. Экспортын чиглэлтэй үйлдвэрийн ажилчдын цалин хөлсийг хүртэл засгийн газраас зохируулж иржээ.²

Тайван, Өмнөд Солонгосын хөгжлийн гарааны үед хэрэгжүүлсэн газрын шинэтгэл нийт эдийн засгийн хөгжилд хүчтэй түлхэц болж өгсөн байна. 1950-аад оны эхээр хэрэгжүүлсэн Тайваны газрын шинэтгэл үндсэндээ гурван хэсгээс бүрдсэн байна. Нэгд, газрын эзэд газраа тариачдад түрээслэн ашиглуулж болох бөгөөд харин тариачдаас хураах түрээсний төлбөрт дээд хязгаар тогтоож өгсөн байна. Хоёрт, засгийн газар улсын мэдэлд байгаа газрын зарим хэсгийг тариачдад хөнгөлөлттэй үнээр, өөрөөр хэлбэл жилийн ургацын 2,5 дахинтай тэнцэх үнээр худалдсан бөгөөд төлбөрийг 10 жилийн хугацаанд хүүгүй авахаар тогтжээ. Гуравт, засгийн газраас 1952 онд тариачдыг газартай болгох бод-

лого явуулж, тогтоосон хэмжээнээс илүү газрыг нь газрын эздээс худалдан авч түүнийг хөнгөлттэй үнээр эргүүлэн газаргүй тариачдад худалдсан байна.³

Өмнөд Солонгост ч 1948 онд газрын шинэтгэлийг тун амжилттай хэрэгжүүлжээ. Үүнээс өмнө тариачдын зөвхөн 14 % нь өөрийн газартай байсан бөгөөд хөдөөгийн хүн амын 4% болох газрын эзэд ихэнх газрыг эзэмшин түрээслэж, түрээсийн хөлсөнд ургацын тал хүртэл хувийг авдаг байв. Газрын шинэтгэлийг хэрэгжүүлснээр хувьд эзэмших газрын хэмжээг 3 га орчмоос хэтрүүлэхгүй болсон нь газар тариалангийн салбарт тариачдын орлогыг тэнцвэртэй болгож өгчээ⁴.

Хөгжлийн эхэн үед 1960-аад оны дунд хүртэл гадаадын тусламж, ялангуяа АНУ-ын тусламжийн үүрэг роль өндөр байсныг бууруулах аргагүй. 1951—1965 оны хооронд америкийн тусламж Тайваны жил бүрийн дотоод хөрөнгө оруулалтын 30-аас дээш хувь, зарим жил 50 %-д хүрч байжээ. АНУ-ын тусламжийн зориулалтын бүтцийг авч үзвэл 37,3%-ийг тээвэр, эрчим хүч, харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулахад; 21,5% -ийг услалтын системийг сайжруулах, үрийн сорт сонгох, тариачдад бага хүүтэй зээллэг олгох зэрэг хөдөө аж ахуйн салбарт; 25,9%-ийг мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд; зөвхөн 15,3 % - ийг боловсруулах аж үйлдвэрийн салбарт бага хүүтэй зээллэг олгоход зарцуулсан байна.⁵ Өөрөөр хэлбэл АНУ-ын тусламжийг аж үйлдвэрийн аль нэг салбарын хөгжлийг түргэтгэхэд бус харин эдийн засгийн дэд бүтцийг ерөнхийд нь сайжруулахад чиглүүлсэн нь оновчтой болжээ.

Өмнөд Солонгост ч 1950-аад онд Америкийн тусламж нийт импортын 5/6-тай тэнцэж шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байв. 1946--1976 оны хооронд Өмнөд Солонгост үзүүлсэн америкийн эдийн засгийн тусламжийн нийт хэмжээ 6 тэрбум орчим ам. доллар болсон бөгөөд түүний 45 % -ийг 1953—1961 оны импорт орлуулах бодлогыг барьж байсан эгзэгтэй үед үзүүлсэн байна.⁶

Хоёр. Тайван, Өмнөд Солонгосын хөгжлийн загварын ижил төстэй ба ялгаатай талууд

Өмнө өгүүлснээс үзвэл хөгжлийнхөө гарааны үед Тайван, Өмнөд Солонгос нь нилээд зүйлээр тун ойролцоо нөхцөл байдалд байсан нь илэрхий. Тайван нь 1895—1945, Өмнөд Солонгос нь 1910— 1945 оны хооронд Японийн колони байсан бөгөөд япончууд энэ хугацаанд тодорхой хэмжээний эдийн засгийн дэд бүтцийг бий болгосон байна. Тайван ч тэр, Өмнөд Солонгос ч тэр ашигт малтмал зэрэг байгалийн нөөц баялагаар хомс байсан нь тэдний хөгжлийн ижил стратегийг сонгон авахад гол түлхэц болж өгчээ. Тайванд тогтсон Гомиьндан нэг намын ноёрхол, Өмнөд Солонгост тогтсон цэргийн дэглэм аль аль нь цөөн тооны газрын эздийн ашиг сонирхлыг бус нийт тариачдын ашиг сонирхлыг гол болгон газрын шинэтгэлийг амжилттай хэрэгжүүлсэн нь цаашдын хөгжлийн үндсийг тавьж өгчээ.

Байгалийн нөөц баялагаар хомс, мөн дотоод зах зээлийн багтаамж бага зэрэг хүчин зүйлүүд нь Тайваныг 1950-иад оны дундуур Өмнөд Солонгосыг 1960-аад оны эхээр экспортийг бүх талаар урамшуулах хөгжлийн шинэ стратегийг сонгон авахад хүргэсэн байна. Мөн банкны зээллэгийн хүүг бодитой өндөр түвшинд байлгаж ингэснээр хувийн хадгаламжийн хүүг байнга инфляцийн түвшнээс өндөрт байлгаж дотоодын хуримтлалыг дайчилж чадсан байна. Түүнчлэн гадаадын валюттай харьцах дотоодын мөнгөн тэмдэгтийн ханшийг бодитой нэг л түвшинд барьж, дотоодын улсын төсвийн орлого нь зарлагаасаа байн-

га илүү байх тийм төсвийн бодлогыг хэрэгжүүлж ирсэн байна. Мөнгө санхүүгийн ийм багц бодлогын үндсэн дээр хямд ажиллах хүчиндээ түшиглэн Тайван болон Өмнөд Слонгос нь хөдөлмөрийн багтаамж ихтэй бүрэн боловсруулсан бэлэн бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд экспортлох замаар хөгжиж 10 гаруйхан жилийн дотор 1970-аад оны эхээр шинээр аж үйлдвэржиж буй орны эгнээнд багтсан билээ.

Хэдийгээр энэ мэт ижил төсөөтэй талуудыг дурьдаж болох боловч Тайван, Өмнөд Солонгосын хөгжлийн загварт зарчмын ялгаатай зүйл цөөнгүй байгааг анзаарахгүй байх аргагүй. Үүнд юуны өмнө эдийн засгийн хөгжилд төрийн үүрэг оролцооны асуудал, үүнээс үүдэн хөрөнгө оруулалтын дотоодын эсвэл гадаадын эх үүсвэрийн алинд илүү тулгуурлах асуудал, түүнчлэн экспортыг өргөжүүлэхдээ жижиг дунд үйлдвэр пүүсэд түшиглэх үү, эсвэл цөөн тооны томоохон пүүс компанид түшиглэх үү зэрэг асуудлууд багтаж байгаа юм.

Өрнөдийн түрүүлж аж үйлдвэржсэн эдийн засгийн хэм хэмжүүрээр авч үзэх юм бол Тайван, Өмнөд Солонгосын аль аль нь эдийн засагт төрийн оролцоог чухалчилдаг гэсэн ангилалд багтана. Өөрөөр хэлбэл Тайван болон Өмнөд Солонгост зах зээлд төрийн зохицуулалт их бага хэмжээгээр байх ёстой гэсэн зарчмыг удирдлага болгосон байна.

Хэдий тиймч засгийн газрын үүрэг роль хир их байх вэ гэдэг асуудлаар Тайван, Өмнөд Солонгосын хооронд ялгаа байсныг хэлэх хэрэгтэй. Зах зээл, ялангуяа хувийн хэвшлийн хөгжилд гүйцэтгэх төрийн оролцоо Тайванд хязгаарлагдмал, шууд бус хэлбэртэй байсан бол Өмнөд Солонгост илүү өргөн шууд байсан байна. Хэрвээ Тайванд хувийн хэвшилд тааламжтай нөхцөл бүрдүүлэхэд засгийн газар голлон анхаарч байсан бол Өмнөд Солонгост тухайн үе шатанд тавьсан зорилтондоо захируулан «болно, болохгүй» гэсэн зарчмаар ажиллажээ.

Тухайн засгийн газар экспортыг өргөжүүлэх стратегия гол нь хэний хүчээр хэрэгжүүлэх вэ гэдэг сонголтоо өөр өөрөөр хийсэн байна. Өмнөд Солонгосын засгийн газар япончуудын үлдээсэн хэдэн голлох үйлдвэрийг цөөн тооны хувийн пүүсүүдэд зарж тэднийг бүх талаар дэмжин тэтгэх бодлого явуулсан байна. Энэ нь аажмаар Өмнөд Солонгосын эдийн засгийн хөдөлгөгч хүч нь цөөн тооны асар том компани (солонгосын чаебол) болоход хүргэжээ. Өмнөд Солонгосын засгийн газар зээллэгийн болон татварын бодлогыг ашиглан экспортод чиглэсэн аж үйлдвэрийг эн түрүүнд дэмжиж ирсэн байна. Засгийн газар өөрийн хяналтанд байсан банкуудаар дамжуулан чухам аль компани пүүсэд хичнээн хэмжээний зээллэг олгох вэ гэдэгт шийдвэрлэх үүрэгтэй байв. Өөрөөр хэлбэл засгийн газар нь тухайн компанийн экспортын үйл ажиллагааны үр дүнг харгалзан цаашид зээллэг олгон өргөжүүлэх, эсвэл зээллэг олгохоос татгалзан хумих, тэр ч байтугай дампууруулах эрх мэдэлтэй байлаа.

Түүнчлэн Тайванаас ялгаатай нь Өмнөд Солонгосын засгийн газар их төлөв гадаадын капитал, гаднын зээллэгт түшиглэх бодлого явуулсан билээ. Нэгэнт засгийн газар гаднын зээллэгийг мэдэлдээ бүрэн авч хянадаг байсан учир зөвхөн засгийн газрын «ивээлд» багтсан пүүс компани л гаднын капитал авч хэрэглэх бололцоотой байв.

Татаварын бодлого ч Өмнөд Солонгосын төрийн зохицуулалтын нэгэн чухал хэрэгсэл байв. Тухайн сонгож авсан салбарт экспорт болон хөрөнгө оруулалтыг өргөжүүлэхийн тулд засгийн газар тухайн салбарын тэргүүлэх компаниас авах ашгийн татварт ихээхэн хөнгөлөлт үзүүлдэг байсан байна. Иймэрхүү зээллэгийн, татварын бодлогын үр дүнд Өмнөд Солонгосын эдийн засагт нийтдээ 30-50 тооны «чаебол»

буюу конгломератууд давамгайлах болжээ. Засгийн газрын төлөвлөгөөтэй нягт уялдан явж ирсэн «чаеболын» ашиг орлого нэмэгдэн үйл ажиллагаа нь байнга өргөжиж ирдэг. 1980-аад оны эхээр Өмнөд Солонгосын 10 томоохон аж үйлдвэрийн конгломерат буюу «чаебол» нь нийт дотоодын бүтээгдэхүүний 75% -ийг үйлдвэрлэж байсныг дурьдахад илүүдэхгүй.⁷

Тайваны санхүү-мөнгөний бодлого Өмнөд Солонгосынхоос ялгаатай байсан байна. 1950-аад оны дундаас эхлэн банкны хүүг өндөр байлгах бодлогыг тууштай явуулснаар хувь хүний хадгаламжийг байнга нэмэгдүүлж хөрөнгө оруулалтыг дотоодын эх үүсвэрт тулгуурлан явуулах боломжтой болжээ. Тухайлбал, Тайваны дотоодын нийт хуримтлал 1965 онд ҮНБ-ий 20 %-тай тэнцэж байсан бол 1973 онд 35 % болж өссөн байна⁸. Тайваны банкуудын хадгаламжийн хүү мөнгөний ханш уналтын түвшнээс үргэлж өндөр байсан явдал өрх гэр, хувь хүмүүсийн мөнгөө хадгалуулах сонирхлыг байнга нэмэгдүүлж ирсэн байна.

Хувийн хуримтлалын түвшин өндөр байсан явдал хувь хүмүүс жижиг болон дунд хэмжээний үйлдвэрлэлийг шинээр эхлэн эрхлэхэд хүчтэй түлхэц болж өгчээ. Түүнчлэн Өмнөд Солонгосын адил банкны зээллэгийг олгохдоо ялгавартай ханддаггүй, харин Тайванд жижиг, дунд оворын үйлдвэрлэлийг үүсгэхэд банкны зээллэгийг авах боломж өргөн байсан байна. Мөн эрчим хүч зэрэг монополь эрх үүсэж болзошгүй аж үйлдвэрийн салбарыг Тайванд улсын мэдэлд байлгаж ирсэн явдал жижиг, дунд оврын үйлдвэрийг үүсэж, хоорондоо өрсөлдөхөд ижил тэгш нөхцөлийг хангаж өгсөн байна.

Хамгийн гол нь Тайваны засгийн газар Өмнөд Солонгосынхтой адил цөөн тооны томоохон компаниудад таатай нөхцөл бүрдүүлэн түрүүлж хөгжүүлэх бодлого баримтлаагүй юм. 1981 оны байдлаар Тайваны нийт пүүс, компанийн тавны дөрөв нь 20-иос хэтрэхгүй ажилчинтай байсан гэдэг тоо бий.⁹ Жижиг болон дунд оврын үйлдвэрүүд нь том пүүс, компанийн захиалгыг гэрээгээр авч гүйцэтгэдэг экспортын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд онцгой хувь нэмэр оруулдаг болох нь тодорхой.

Олон тооны жижиг болон дунд оврын үйлдвэртэй байх нь хэд хэдэн давуу талтай болох нь маргаангүй. Юуны өмнө жижиг үйлдвэрүүд нь том пүүсийг бодвол зах зээлийн нөхцөл байдал өөрчлөгдөхөд дагалдан түргэн уян хатан зохицох чадвартай байдаг. Түүнчлэн жижиг, дунд оврын бизнес нь зах зээлийн өрсөлдөөнийг байнга тэтгэж, шинэ шинэлэг зүйлийг эрэлхийлж аж ахуйч шинжийг үргэлж хадгалж байдаг онцлогтой. Түүгээр ч барахгүй Тайваны олон тооны жижиг, дунд үйлдвэрүүд нь баян хоосны ялгааг хэт ихэсгэлгүй, хүн амын орлогыг жигд тэнцвэртэй нэмэгдүүлэх бололцоог олгодог байна,

Гурав. Туршлага, сургамж

Азийн 4 бар, ялангуяа Тайван, Өмнөд Солонгосын хөгжлийн гарааны нөхцөл байдлыг аваад үзвэл нийтлэг талууд олон байна. Юуны өмнө хэдэн арван жилийн турш Японы колонийн бүрэлдэхүүнд багтаж, тэдний барьж байгуулсан эдийн засгийн дэд бүтэц дээр ямар нэг хэм жээгээр тулгуурлах бололцоотой байв. Мөн АНУ-ын цэрэг, эдийн засгийн тусламж 1960-аад оны дунд хүртэл Тайван, Өмнөд Солонгосын импортыг нөхөх, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг өргөтгөхөд далайцтай үүрэг гүйцэтгэсэн байна.

Хэдий тийм ч экспорт урамшуулах хөгжлийн шинэ бөгөөд нэн ирээдүйтэй стратегийг сонгон авахад дотоодын хүчин зүйлүүд шийдвэрлэх үүрэгтэй байжээ. Юуны өмнө ашигт малтмал зэрэг байгалийн нөөц

баялгаар хомс тарчиг, хүн ам харьцангуй цөөнөөс (Тайван 20 сая, Өмнөд Солонгос 40 сая хүн амтай) шалтгаалан дотоодын зах зээлийн багтаамж багатай нь хөгжлийн ийм стратегийг сонгон авахад хүргэжээ. Мөн хямд хөлстэй ажиллах хүчин элбэг байсан явдал хөдөлмөрийн багтаамж ихтэй аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн дэлхийн зах зээл дээр өрсөлдөх боломжийг бүрдүүлж өгчээ. Түүнчлэн Японы хөгжлийн загвараас бүтээлчээр суралцан экспортыг урамшуулах, ялангуяа экспортын чиглэлтэй аж үйлдвэрийг төрийн зүгээс тодорхой хугацаанд «ивээн тэтгэх» бодлогыг амжилттай хэрэгжүүлсэн байна.

АЗИЙН ДӨРВӨН БАРЫН ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Орон	Хүн ам (1987 он)	Нэг хүнд ноогдох ДНБ		Газар нутаг (1000 км ²)	Дотоодын нийт бүтээгдэхүүн (млрд, ам.дол)		ДНБ-ний жилийн өсөлт		Гадаад худалдаа млрд. ам/дол	
		1987 он ам, доллар	Өсөлтийн % (1965-1987)		1965	1987	1965-1980	1980-1987	Экспорт	Импорт
Өмнөд Солонгос	42,1 сая	2690	6,4%	98	3	121,3	9,5%	8,6%	47,2	40,9
Тайван	19,5 сая	5043	6,6%	39	2,8	97,2	9,3%	7,3%	53,5	35
Гонконг	5,6 сая	8070	6,2%	1	2,2	36,5	8,6%	5,8%	48,5	48,5
Сингапур	2,6 сая	7940	7,2%	1	1	19,9	10,1%	5,4%	28,6	32,5

Тайван, Өмнөд Солонгосын экспортыг хэдэн арав дахин нэмэгдүүлж, 1970-аад оны эх гэхэд шинээр аж үйлдвэржиж буй орны статуст хүргэхэд төрийн үүрэг роль өндөр байсныг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Үндэсний хөгжлийн зорилгыг хөтөлбөрөө болгосон засгийн газар, түүний хөтөлбөрийг өндөр түвшинд боловсруулан хэрэгжүүлэх чадвартай улсын төлөвлөгөөний газрууд нь Тайван, Өмнөд Солонгосын хөгжлийг хөтлөн жолоодох чадвартай, бүрэн эрх мэдэлтэй байсанд хэргийн учир оршино. Засгийн газар нь эдийн засгийн хууль тогтоомжийг мөрдүүлэх, банкны зээллэгийн сахилга батыг чанд мөрдүүлэх, албан татварыг цагт нь хураах бүрэн чадвартай хүчтэй байсан байна. Гэвч тэдгээрийн засгийн газар нь мөн чөлөөт зах зээлийн ач холбогдлыг бүрэн ухамсарлаж эдийн засагт хэт их оролцохоос өөрсдийгөө сэргийлж чадсан байна.

1. San Gee, The Economic Development of Taiwan, R.O.C. Experiences and Challenges, Occasional Paper, CIER, December 1991, No 9112, p. 5
2. Byung-Nak Song, The Rise of the Korean Economy, Oxford Univ. Press, 1990, p. 97
3. San Gee, p. 7—8
4. Byung-Nak Song, p. 176
5. San Gee, p. 8—9
6. The Political Economy of the New Asian Industrialism, Cornell University Press, 1987, p. 87
7. Models of Development: A comparative study of Economic Growth in South Korea and Taiwan, Executive Summary, ICS Press, 1990, p. 22
8. Мөн тэнд p. 17
9. Andrew B. Brick, The East Asian Development Miracle: Taiwan as a Model, in «Issues and Studies», vol. 28, No 8, August 1992, p. 7